



НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 26 өдөр

Дугаар A/150.

Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгож,
журам шинэчлэн батлах тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын Дүрэм батлах тухай 2017 оны 170 дугаар тогтоол, 2018 оны 97 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын “Захиалагчийн техник хяналтын журам”-ыг нэгдүгээр, уг журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой маягт, баримт бичгийн бүрдлийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.


2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер /Г.Цэрмаа/-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2016 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/16 тоот тушаал, 2017 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/16 тоот тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б. МӨНХБАТ



315060000640

Нийслэлийн хөрөнгө оруулалтын
газрын даргын 2018 оны 2 сарын 16-ний
өдрийн А/С дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИК ХЯНАЛТЫН ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар /цаашид “газар” гэх/-ын Захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах, ажлын уялдаа холбоог сайжруулах, ажил үүргийн хуваарийг оновчтой тогтооход энэ журмын зорилго оршино.

1.2. Техник хяналт нь Зөвлөх үйлчилгээний техник хяналт, Барилгын ажлын техник хяналт гэсэн үндсэн хэсгээс бүрдэнэ. Барилгын ажлын техник хяналт гэж Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11-д заасныг /цаашид “барилгын ажил” гэх/, Зөвлөх үйлчилгээний техник хяналт гэж Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29-д заасан /цаашид “Зөвлөх үйлчилгээ” гэх/ ажилд техник хяналт хийх үйл ажиллагаа гэж тус тус ойлгоно.

1.3. Техник хяналтыг хэрэгжүүлэхэд Барилгын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Барилгын ажлын захиалагчийн дүрэм, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, энэ журам болон холбогдох бусад эрх зүйн актыг мөрдөнө.

ХОЁР. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИК ХЯНАЛТ

2.1. Зураг төслийн хэлтсээс зөвлөх үйлчилгээний ажилд техник хяналт тавина. Хяналтыг зөвлөмж хүлээн авах, гэрээ байгуулах, ажлын зураг эхлүүлэх, зураг төсөл боловсруулах явцын хяналт тавих болон хүлээн авах гэсэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.2. ЗӨВЛӨМЖ ХҮЛЭЭН АВАХ ҮЕ ШАТ

2.2.1. Хариуцсан инженер Үнэлгээний хорооноос ирүүлсэн зөвлөмж, холбогдох материалыг хүлээн авч гэрээ байгуулах эсвэл зөвлөмжийг буцаах асуудлыг энэ журмын хавсралт маягт №11 “Зураг төслийн ажлын тендерийн баримт бичгийг нягтлан шалгах хяналтын карт”-ын дагуу ажлын 2 хоногт багтаан шалгаж эцэслэн шийдвэрлэнэ.

2.2.2. Шаардлага хангаагүй тендерийн баримт бичгийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 46 дугаар зүйлийн 46.1.2 дахь хэсэгт заасны дагуу үнэлгээний хороонд буцаах тухай албан бичиг төлөвлөж ахлах инженер, хэлтсийн дарга нартай хамтран зөвшилдөж, үнэлгээний хороонд буцаах шийдвэрийг гаргана.

2.2.3. Шаардлага хангасан үнэлгээний хорооны зөвлөмжийн хувьд гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүргүүлэх албан тоотыг ахлах инженер, хэлтсийн даргаар хянуулан гэрээний загвар, хөрөнгийн захирамж, үнэлгээний

хорооны зөвлөмжийг хуулбарлан хавсаргаж гүйцэтгэгчид хүргүүлэх бөгөөд үнэлгээний хороонд мэдэгдэнэ.

2.2.4. Зөвлөмж буцаах тухай албан бичиг, гэрээ байгуулах мэдэгдлийг хяналтын инженер, ахлах инженер, Хэлтсийн дарга, Ерөнхий инженер болон Хууль, дотоод хяналтын алба хянаж газрын даргаар баталгаажуулна.

2.3 АЖЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ҮЕ ШАТ

2.3.1 Гүйцэтгэгчтэй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасан хугацаанд /тендерийн хүчинтэй хугацаанд/ ажлын 3 хоногт багтаан **гэрээ байгуулна.**

2.3.2 Хариуцсан инженер гэрээ байгуулахад батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгавар, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгаврыг гэрээнд хавсаргана.

2.3.3 Гүйцэтгэгч гэрээг баталгаажуулан Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан ирүүлнэ. НХОГ-ын Дотоод үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн журмын дагуу хавсралт маягт №2¹ **“Зураг төслийн ажлын гэрээний хяналтын карт”**-ын дагуу хүлээн авч хариуцсан инженерт ажлын 1 өдрийн дотор хүргүүлнэ.

2.3.4 Гэрээний бүрдэл хангагдсан гэж үзвэл хяналтын инженер гэрээг 5 хувь хэвлэж, ахлах инженер, Хууль, дотоод хяналтын алба, Хэлтсийн дарга, Санхүү аж ахуйн хэлтсийн дарга, Ерөнхий инженер нараар тус тус хянуулж газрын даргаар баталгаажуулж холбогдох газарт хүргүүлнэ.

2.3.5 Гэрээ баталгаажих явцад засвар оруулах тохиолдолд хавсралт маягт №8-ийн дагуу **Хяналтын хуудас** хөтөлнө.

2.3.6 Гэрээний хяналтын картыг 2% үйлдэнэ. Хяналтын картын нэг хувийг Санхүүгийн мэргэжилтэн архивын нэгж болгон хадгална.

2.4 АЖЛЫН ЗУРАГ ЭХЛҮҮЛЭХ ҮЕ ШАТ

2.4.1 Гүйцэтгэгч батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгавар, инженер геологийн дүгнэлт, байр зүйн дэвсгэр зураг, эскиз зураг төслийг боловсруулж, ирүүлэх ба Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан НХОГ-ын Дотоод үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн маягт 8² **“Барилгын эскиз зураг төсөл зөвшилцөн баталгаажуулах бүрдэл”**-ийн дагуу хүлээн авч, хариуцсан хяналтын инженерт тухайн өдөрт шилжүүлнэ.

2.4.2 Газрын мэргэжилтэн байр зүйн дэвсгэр зургийг, гидротехникийн инженер геологийн дүгнэлтийг **ажлын 2 хоногийн дотор** шалгаж баталгаажуулна.

2.4.3 Хариуцсан хяналтын инженер эскиз зураг төслийг архитектур төлөвлөлтийн даалгаврын дагуу хийгдсэн эсэхийг шалгаж, ашиглагч болон Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 97 дугаар “Дүрэм батлах тухай” тогтоолын хавсралт **“Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”**-ийн дагуу шаардлагатай байгууллагуудтай зөвшилцсөний дараа хэлтсийн дарга, Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, зураг төсөл хариуцсан орлогч дарга, Ерөнхий инженерт танилцуулан, газрын даргаар баталгаажуулж **ажлын 2 өдрийн дотор** НХТЕТГ-т албан тоот бичгээр хүргүүлнэ.

2.4.4 Гадна инженерийн шугам сүлжээний ажлын зургийг эхлэхээс өмнө трассыг НХТЕТГ, ашиглагч, хангагч байгууллагуудтай зөвшилцөх ажлыг хариуцсан хяналтын инженер, гүйцэтгэгчтэй хамтран гүйцэтгэнэ.

2.4.5 Хариуцсан хяналтын инженер, батлагдсан эскиз зураг, шугам сүлжээний трасс, засварын ажлын хэмжилтийн зургийг үндэслэн гүйцэтгэгчид ажлын зураг төслийн **ажлыг эхлүүлэх** зөвшөөрөл олгоно.

2.4.6 Гэрээний тусгай нөхцөлд заасан эхний санхүүжилт олгох гүйцэтгэлийг маягт №9¹ **“Зураг төсвийн ажлын эхний санхүүжилт олгох гүйцэтгэлийн баримт бичгийн бүрдэл”**-ийн дагуу Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан НХОГ-ын Дотоод үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн хүлээн авч **ажлын 1 өдөрт багтаан** хариуцсан хяналтын инженерт шилжүүлнэ. Хяналтын инженер энэ журмын хавсралт маягт №3¹ **“Зураг төслийн ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”**-ын дагуу ажлын 4 хоногт багтаан ахлах инженер, хэлтсийн дарга, Санхүү аж ахуйн хэлтэс, ХДХА, Ерөнхий инженерээр хянуулан баталгаажуулсныг газрын дарга албажуулна.

2.4.8 Гүйцэтгэл баталгаажих явцад засвар оруулах тохиолдолд хавсралт маягт №8-ийн дагуу **Хяналтын хуудас** хөтөлж Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан НХОГ-ын Дотоод үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн гүйцэтгэгчид буцаана.

2.4.9 Гүйцэтгэлийн хяналтын картыг 2% үйлдэж, нэг хувийг Санхүүгийн мэргэжилтэн архивын нэгж болгон хадгална.

2.5. ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЯВЦЫН ХЯНАЛТ ТАВИХ

2.5.1 Хяналтын инженер батлагдсан эскиз зураг, архитектур төлөвлөлтийн даалгавар, ажлын зургийн даалгаврын дагуу шаардлагатай техникийн үзүүлэлтийг гүйцэтгэгчээс гаргуулан авч, **ажлын 2 хоногийн дотор** хангагч байгууллагууд руу техникийн нөхцөл хүссэн албан тоот хүргүүлнэ. Техникийн нөхцөл гаргуулах ажлыг хяналтын инженер, ахлах инженер, хэлтсийн дарга нар хамтран зохион байгуулна. Хангагч байгууллагаас техникийн нөхцөл баталгаажсан өдөрт нь багтаан гүйцэтгэгчид хүргүүлнэ.

2.5.2. Техникийн нөхцөлүүд шийдвэрлэгдэх хугацаанд хариуцсан хяналтын инженер дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Үндсэн барилгын ажлын зураг төслийг хүлээн авч чиглэл тус бүрээр хариуцсан хяналтын инженерүүдэд тараан өгч **ажлын 3 өдрийн дотор хянуулан** дүгнэлт гаргуулна.

2. Дүгнэлт гаргасан инженерүүд төсөл хариусан хяналтын инженерт Маягт 4а –ийн дагуу санал зөвлөмжөө өгөх ба хяналтын инженер Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан гүйцэтгэгч байгууллагад хүргүүлэн, **хуанлийн 3-5 хоногийн** дотор шаардлагатай засвар өөрчлөлтийг гүйцэтгүүлэх үүрэг даалгавар өгч зөрчлийг арилгуулна.

3. Бэлэн болсон ажлын зургийг хүлээн авч хэлтсийн дарга, Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, зураг төсөл хариуцсан орлогч, Ерөнхий инженерээр хянуулан газрын даргаар баталгаажуулж ОБЕГ болон НОБГазраар дүгнэлт гаргуулахаар гүйцэтгэгч компанид өгнө.

2.5.3 Техникийн нөхцлүүд баталгаажсан даруй хариуцсан хяналтын инженер гадна шугам сүлжээний ажлын зургийг гүйцэтгүүлж, холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний дагуу нэгдсэн хяналтын төсөв хийлгэж, иж бүрэн дууссан ажлын зураг төсвийг хүлээн авч, чиглэл тус бүрээр хариуцсан инженерүүдэд тараан өгч **ажлын 3 өдрийн дотор** дүгнэлт гаргуулна.

2.5.4 Дүгнэлт гаргасан инженерүүд төсөл хариусан инженерт Маягт 4а –ын дагуу санал зөвлөмжөө өгөх ба инженер нь Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан гүйцэтгэгч байгууллагад хүргүүлэн, **хуанлийн 3-5 хоногийн дотор** шаардлагатай засвар өөрчлөлтийг гүйцэтгүүлэх үүрэг даалгавар өгч зөрчлийг арилгуулна.

2.5.5 Бэлэн болсон ажлын зураг төслийг журмын хавсралт маягт 8¹ **“Барилгын зураг төслийн ажлын явцын тайлан зөвшилцөн баталгаажуулах ажлын баримт бичгийн бүрдэл шалгах хяналтын хуудас”**, засварын ажлын зураг төслийн бүрдлийг маягт 8³ **“Засварын зураг төслийн ажлын явцын тайлан зөвшилцөн баталгаажуулах ажлын баримт бичгийн бүрдэл шалгах хяналтын хуудас”**, Инженерийн шугам сүлжээний зураг төслийг маягт 8⁴ **“Инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлын явцын тайлан зөвшилцөн баталгаажуулах бүрдэл шалгах хяналтын хуудас”*-уудын** дагуу Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан НХОГ-ын Дотоод үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн хүлээн авч хариуцсан инженерт **тухайн өдөрт** шилжүүлнэ.

2.5.6 Иж бүрэн боловсруулсан, ажлын зураг төсөв нь Шаардлага хангасан тохиолдолд хариуцсан хяналтын инженер, ахлах инженер, хэлтсийн дарга, Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, зураг төсөл хариуцсан орлогч, Ерөнхий инженерээр хянуулан гарын үсэг зуруулж, газрын даргаар баталгаажуулан Магадлалын дүгнэлт гаргуулахаар холбогдох байгууллага руу албан тоот бичгээр хүргүүлнэ.

2.5.7 Хариуцсан хяналтын инженер нь зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын явцад гэрээний биелэлтэд хяналт хийхээс гадна техникийн шийдэл, материал тоног төхөөрөмжийн сонголт, техник эдийн засгийн тооцооны явцад мөрдөгдөж байгаа БНБД-ийн хүрээнд хяналт тавьж, гүйцэтгэгчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч заавал зөвшилцөх байгууллагуудтай зөвшилцөх явцад хамтран ажиллана.

2.5.8 Хариуцсан хяналтын инженер нь зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх явцад “Техникийн зөвлөлийн ажиллах журам”-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд “Техникийн зөвлөлийн хурал”-аар оруулан шийдвэрлүүлж, шийдвэрийг холбогдох газруудад **ажлын 2 хоногийн дотор** хүргүүлнэ.

2.5.9 Хариуцсан хяналтын инженер ажлын явцын мэдээллийг хөрөнгө оруулалтын мэдээллийн сангийн программд 7 хоног тутам оруулах бөгөөд ахлах инженер, хэлтсийн дарга хянаж байна.

2.5.10 Гэрээний тусгай нөхцөлд заасан явцын санхүүжилт олгох гүйцэтгэлийн бичиг баримтын бүрдлийг маягт №9¹ **“Зураг төсвийн ажлын санхүүжилт олгох гүйцэтгэлийн баримт бичгийн бүрдэл”**-ийн дагуу Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан НХОГ-ын Дотоод үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн хүлээн авч **ажлын 1 өдөрт багтаан** хариуцсан хяналтын инженерт шилжүүлнэ.

2.5.11 Хариуцсан хяналтын инженер шалган холбогдох албан тушаалтнуудаар гарын үсэг зурж баталгаажуулсны дараа газрын дарга албажуулна.

2.5.12 Гүйцэтгэл баталгаажих явцад засвар оруулах тохиолдолд хавсралт маягт №8-ийн дагуу Хяналтын хуудас хөтлөн Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан НХОГ-ын Дотоод үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн гүйцэтгэгчид буцаана.

2.5.13 Гүйцэтгэлийн хяналтын картыг 2% үйлдэж, нэг хувийг Санхүүгийн мэргэжилтэн архивын нэгж болгон хадгална.

2.6. ЗУРАГ, ТӨСӨЛ ХҮЛЭЭН АВАХ ҮЕ ШАТ

2.6.1 Магадлал хийгдсэн ажлын зураг төслийг маягт №9² *“Магадлал хийгдсэн ажлын зураг төслийг хүлээлцсэн акт”*-ын дагуу гэрээнд заасны дагуу эх хувь -1, хуулбар хувь-2, СД дээр бичигдсэн файл хэлбэрээр хариуцсан хяналтын инженер, ахлах инженер, хэлтсийн дарга гарын үсэг зурж хүлээн авна.

2.6.2 Хариуцсан хяналтын инженер энэ журмын хавсралт маягт №5¹ *“Зураг төсвийн ажлын гэрээ дүгнэсэн протокол”*-ын дагуу гэрээг дүгнэн, проткол үйлдэж ахлах инженер, хэлтсийн дарга, санхүү аж ахуйн хэлтсийн дарга, ХДХА болон гүйцэтгэгч компаниар баталгаажуулан гарын үсэг зурснаар ажлыг дуусгана.

2.6.3 Хариуцсан хяналтын инженер зураг төслийг ажлын 2 хоногт мэдээллийн санд оруулах бөгөөд шаардлагатай тохиолдолд зураг төслийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, дүүргүүд болон бусад байгууллагуудад журмын хавсралт маягт №4^{1а} *“Зураг төсөв хүлээлцэх акт”*-аар ажлын 3 хоногийн дотор хүлээлгэн өгнө.

2.6.4 Барилга захиалагчийн хэлтэст шууд хүлээлгэн өгөх тохиолдолд объект хариуцсан хяналтын инженер, ахлах инженер, хэлтсийн дарга болон Зураг төслийн хэлтсийн хариуцсан инженер, ахлах инженер, хэлтсийн дарга хянаж журмын хавсралт маягт №4^{1б} *“Зураг төсөв хүлээлцэх акт”*-ын дагуу хүлээлцэж шилжүүлнэ.

2.6.5 Зураг төсвийн ажлын техникийн баримт бичгийн бүрдлийг журмын хавсралт маягт №6¹ *“Зураг төслийн ажлын баримт бичгийн бүрдэл”*-ийн дагуу бүрдүүлэн ажил дууссан улиралд багтаан архивын нэгж болгон архивт хүлээлгэж өгнө.

2.6.6 Гэрээний тусгай нөхцөлд заасан эцсийн санхүүжилт олгох гүйцэтгэлийн бичиг баримтын бүрдлийг маягт №9¹ *“Зураг төсвийн ажлын санхүүжилт олгох гүйцэтгэлийн баримт бичгийн бүрдэл”*-ийн дагуу Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан НХОГ-ын Дотоод үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн хүлээн авч ажлын 1 өдөрт багтаан хариуцсан хяналтын инженерт шилжүүлнэ.

2.6.7 Хариуцсан хяналтын инженер энэ журмын хавсралт маягт №3¹ *“Зураг төслийн ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”*-ын дагуу ажлын 4 хоногт багтаан холбогдох албан тушаалтнуудаар хянуулж гарын үсэг зуруулж баталгаажуулсны дараа газрын дарга албажуулна.

2.6.6 Гүйцэтгэл баталгаажих явцад засвар оруулах тохиолдолд хавсралт маягт №8-ийн дагуу Хяналтын хуудас хөтлөн Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан НХОГ-ын Дотоод үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн гүйцэтгэгчид буцаана.

2.6.8 Гүйцэтгэлийн хяналтын картыг 2% үйлдэж, нэг хувийг Санхүүгийн мэргэжилтэн архивын нэгж болгон хадгална.

ГУРАВ. БАРИЛГЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТ

3.1. Барилга захиалагчийн хэлтсээс барилгын ажилд захиалагчийн техникийн хяналт гүйцэтгэнэ. Хяналтыг үнэлгээний хорооны зөвлөмж хүлээн авах, гэрээ байгуулах, ажил эхлүүлэх, ажлын явцад хяналт тавих, ажил дуусгах гэсэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.2. ЗӨВЛӨМЖ ХҮЛЭЭН АВАХ ҮЕ ШАТ

Хяналтын инженер үнэлгээний хорооноос ирүүлсэн зөвлөмж, холбогдох материалыг хүлээн авч гэрээ байгуулах эсвэл зөвлөмжийг буцаах асуудлыг энэ журмын хавсралт маягт №1² **“Барилгын ажлын тендерийн баримт бичиг магадлан шалгах хяналтын карт”**-ын дагуу ажлын 3 өдрийн дотор холбогдох албан тушаалтнууд шалгаж шийдвэрийг гаргана. Зөвлөмж буцаах тухай албан бичиг, гэрээ байгуулах мэдэгдлийг хяналтын инженер, ахлах инженер, Хэлтсийн дарга, Ерөнхий инженер болон Хууль, дотоод хяналтын алба хянаж газрын даргаар баталгаажуулна.

3.2.1. Шаардлага хангаагүй тохиолдолд тендерийн баримт бичгийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 46 дугаар зүйлийн 46.1.2 дахь хэсэгт заасны дагуу үнэлгээний хороонд албан тоотоор буцаана.

3.2.2. Шаардлага хангасан тохиолдолд зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэлд гэрээний загвар, хөрөнгийн захирамж, үнэлгээний хорооны зөвлөмжийг хуулбарлан хавсаргана.

3.3. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ҮЕ ШАТ

3.3.1. Гүйцэтгэгчтэй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасан хугацаанд /тендерийн хүчинтэй хугацаанд/ ажлын 3 хоногт багтаан **гэрээ байгуулна**.

3.3.2. Гүйцэтгэгч гэрээг баталгаажуулан, ажил эхлүүлэх үргэжлүүлэх зөвшөөрөл авахад шаардагдах бичиг баримтыг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд ирүүлнэ. НХОГ-ын Дотоод үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн энэ журмын хавсралт маягт №2² **“Барилгын ажлын гэрээний хяналтын карт”**, **“Ажил эхлүүлэх үргэжлүүлэх зөвшөөрөл”**-н дагуу хүлээн авч хариуцсан инженерт ажлын 1 өдрийн дотор хүргүүлнэ.

3.3.3. Гүйцэтгэгчийн баталгаажуулан ирүүлсэн гэрээг хяналтын инженер, бүсийн ахлах инженер, ХДХА, Барилга захиалагчийн хэлтсийн дарга, Санхүү аж ахуйн хэлтэс, Ерөнхий инженер нар хянаж баталгаажуулах ба газрын дарга албажуулна.

3.3.4. Хяналтын инженер барилга **угсралтын ажлын гэрээ байгуулах үед** тухайн объектын **зохиогчийн хяналтын гэрээг** батлагдсан загварын дагуу бэлтгэж гүйцэтгэгчид хүргүүлнэ.

3.3.5. Гэрээг зохиогч компани баталгаажуулж ирэхэд энэ журмын хавсралт маягт №2³ **“Зохиогчийн хяналтын гэрээний хяналтын карт”**-ын дагуу хянуулж баталгаажуулна.

3.3.6. Зохиогчийн хяналтыг “Барилгын тухай хууль”- ийн 38.1.4 дэх заалт, “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх дүрэм” /БНБД 11-04-16/-ийн дагуу хийлгэнэ.

3.3.7. Хяналтын инженер Барилга угсралтын ажлын явцад ажлын зурагт өөрчлөлт гарах, үүнтэй уялдан төсөвт өртөгт өөрчлөлт орсон тохиолдолд зохиогчоор заавал баталгаажуулна.

3.3.8. Түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг байгуулахдаа зураг төслийн хэлтэстэй хамтран байгуулах бөгөөд зураг төсөл боловсруулах явцыг энэ журмыг хоёрдугаар хэсэгт заасны дагуу Зураг төсөл газар зохион байгуулалтын хэлтэс хариуцан хэрэгжүүлнэ. Зураг төсөл батлагдсны дараа захиалагчийн хэлтсийн хяналтын инженер энэ журмын 2.6.4-ийн дагуу хүлээн авч, тендерт ирүүлсэн ажлын тоо хэмжээг дахин шалгаж, зохиогчийн хяналтын гэрээ байгуулан ажиллана.

3.4. БАРИЛГЫН АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ ҮЕ ШАТ

3.4.1. Засгийн газрын 2017 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, зөвшөөрөл олгох дүрэм”-ийн дагуу холбогдох бичиг баримтыг бүрдүүлэнэ.

3.4.2. Шаардлагатай тохиолдолд барилгын ажлын талбайг холбогдох байгууллагатай хамтарч чөлөөлүүлэх, газар шорооны ажил эхлэхээс өмнө холбогдох дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний байгууллагуудад мэдэгдэж зөвшөөрөл авах ажлыг гүйцэтгэгчтэй хамтран хяналтын инженер, бүсийн ахлах инженер, хэлтсийн дарга, Зураг төслийн хэлтэс болон хяналтын инженерүүд зохион байгуулна.

3.4.3. Хяналтын инженер барилгын ажлын зургийн хуулбарыг дардас дарж, баталгаажуулан гүйцэтгэгч байгууллагад хүлээлгэн өгнө.

3.4.4. Хяналтын инженер, бүсийн ахлах инженер нар барилгын **талбайд ажил эхлүүлэх тухай тэмдэглэл** үйлдэн, улаан шугам татаж, тэг тэнхлэг байгуулах актыг гүйцэтгэгч, болон геодезийн мэргэжлийн байгууллагагаар баталгаажуулан **барилгын ажлыг эхлүүлнэ.**

3.4.5. Хяналтын инженер нь барилгын ажил явагдаж байгаа талаар дэлгэрэнгүй тайлбартай самбар /анхааруулга самбар/ байрлуулах, боломжтой тохиолдолд шаардлага хангасан хашаа бариулах, барилга угсралтын ажлын үед орчны аюулгүй ажиллагаа хангах ажлыг БНБД болон бусад хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу гүйцэтгэгч байгууллагаар заавал хийлгүүлнэ.

3.5. БАРИЛГЫН АЖЛЫН ЯВЦЫН ҮЕ ШАТ

3.5.1. Барилгын ажлыг гүйцэтгэх явцад Барилга захилагчийн хэлтэс барилгын ажил үргэлжлэх хугацаа, чанар /ажлын, барилгын материалын чанар, өнгө, үзэмж, сонголт/ ажлын гүйцэтгэлд гэрээний явцын **хяналтыг гүйцэтгэж** мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

3.5.2. Барилгын ажлын явцын хяналтын үе шатанд **хяналтын инженерүүд** өөрийн мэргэшлийн хүрээнд дараах ажлыг гүйцэтгэнэ.

- Барилга угсралтын ажлын явцад ажлын технологи, чанарт өдөр тутам хяналтыг тавих, шаардлагатай заавар, зөвлөмж, шаардлага өгөх, тэдгээрийнхээ биелэлтийг хангуулах;
- Фото зургаар баримтжуулсан ил, далд ажлын актыг баталгаажуулж дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэх зөвшөөрөл олгох;
- Барилгын ажил гүйцэтгэсэн тэмдэглэлийг гүйцэтгэгчээр хөтлүүлэх ба захиалагчийн хяналт хийсэн тухай тэмдэглэл хэсэгт талбайд ажиллах бүрдээ тэмдэглэл хийх;
- Шаардлагатай барилгын материалын сорилт шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор хийлгэх, материал өнгө, стандартын шаардлага хангасан өөр материал түүхий эдээр оруулах эсэхийг зохиогчтой хамтран шийдэх;
- Гэрээний үүргийн биелэлтэд хяналт хийх /батлагдсан график, гэрээт хугацаа г.м/;
- Барилгын ажлын явцад зохиогчоор хяналт хийлгэх ажлыг зохиогчийн хяналтын гэрээний дагуу зохион байгуулах;
- Барилгын ажлын явцад Техникийн зөвлөлийн ажиллах журамд заасан үндэслэл бий болсон тохиолдолд асуудлыг тухай бүр "Техникийн зөвлөлийн хурал"-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, шийдвэрийг холбогдох байгууллага албан тушаалтанд **ажлын 2 өдрийн дотор** хүргүүлэх;
- Шаардлагатай тохиолдолд барилгын ажлын гүйцэтгэлийн зураг хийлгэх, геодезийн хэмжилтээр баталгаажуулах болон мэдээллийн санд файлаар оруулах ажлыг зохиогч, гүйцэтгэгчтэй хамтран зохион байгуулах;
- Өөрийн хариуцан ажиллаж байгаа төсөл арга хэмжээтэй холбоотой албан бичиг, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх ажлыг хуулийн хугацаанд багтаан зохион байгуулах;
- Ажлын үе шатны мэдээлэлийг хөрөнгө оруулалтын мэдээллийн сангийн программд фото зургаар баяжуулан долоо хоног бүр оруулах;
- Гүйцэтгэгчээс ирүүлсэн санхүүжилт хүссэн гүйцэтгэлийн бичиг баримтыг **ажлын 4 хоногт** багтаан хянаж баталгаажуулах;
- Гэрээт ажил дуусвар болох бүрт энэ журмын хавсралт **маягт №5² "Барилгын ажлын гэрээ дүгнэсэн протокол"**-ын дагуу гэрээг дүгнэн протокол үйлдэх;

3.5.3. Барилгын ажлын явцын хяналтын үе шатанд бүсийн **ахлах инженерүүд** дараах ажлыг гүйцэтгэнэ.

- Хяналтын инженерийн өдөр тутмын үйл ажиллагаа, бичиг баримтын хөтлөлтөд хяналт хийх, анхан шатны удирдлагаар хангах;
- Барилга угсралтын явц, чанар байдалд давхар хяналт хийх
- Хяналтын ажил дээр хамтран ажиллаж байгаа инженерүүдийн хоорондын уялдаа холбоог хангаж өдөр тутмын нэгдсэн удирдлагаар хангах;
- Гүйцэтгэгч, хяналтын инженерүүдийн хооронд үүссэн маргаан, үл ойлголцолыг шийдвэрлэх;
- Ажил гүйцэтгэх явцад гүйцэтгэгчээс болон бусад байгууллагаас шалтгаалсан асуудлуудыг судлаж, шийдвэрлэх, хурал, уулзалт зохион байгуулах;
- Ажлын үе шатны мэдээлэлийг хөрөнгө оруулалтын мэдээллийн сангийн программд долоо хоног бүр үнэн зөв оруулсан эсэхийг хянах;

- Гүйцэтгэгчээс ирүүлсэн санхүүжилт хүссэн гүйцэтгэлийн бичиг баримтыг хяналтын инженер үнэн зөв хянасан эсэхийг **тухайн өдөрт нь** хянаж баталгаажуулах;

3.5.4. Барилгын ажлын явцын хяналтын үе шатанд **Барилга захиалагчийн хэлтсийн дарга** дараах ажлыг гүйцэтгэнэ.

- Төслүүдийн хэрэгжилтэд тавьж байгаа хяналтын ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, ИТА-ны хоорондын уялдаа холбоог зохицуулах;
- Бүсийн ахлах болон хяналтын инженерүүдийг өдөр тутмын удирдлагаар хангах;
- Барилга угсралтын явцын байдалтай газар дээр танилцаж, ахлах болон хяналтын инженерүүдэд заавар зөвлөлгөө өгөх;
- Ажил гүйцэтгэх явцад гүйцэтгэгчээс болон бусад байгууллагаас шалтгаалсан асуудлуудыг шийдвэрлэх, хурал, уулзалт зохион байгуулах;
- Газрын удирдлагад гэрээний хэрэгжилтийн талаар үнэн зөв мэдээлэл өгөх;
- Ажлын үе шатны мэдээлэлийг хөрөнгө оруулалтын мэдээллийн сангийн программд долоо хоног бүр үнэн зөв оруулсан эсэхийг хянах;
- Гүйцэтгэгчээс ирүүлсэн санхүүжилт хүссэн гүйцэтгэлийн бичиг баримтыг үнэн зөв эсэхийг **тухайн өдөрт нь** хянаж баталгаажуулах;
- Гэрээ дүгнэсэн протоколыг баталгаажуулах;

3.5.5. Барилгын ажлын явцын хяналтын үе шатанд **Ерөнхий инженер** дараах ажлыг гүйцэтгэнэ.

- Барилгын ажил гүйцэтгэсэн тэмдэглэлийг / *улаан дэвтэр*/ баталгаажуулна.
- Барилга захиалагчийн хэлтсийг өдөр тутмын удирдлагаар хангаж, хяналтын ажлыг шат шатандаа хариуцлагатай хийсэн эсэхийг шалгаж буруутай этгээдэд хариуцлага хүлээлэгдэх саналыг газрын даргад танилцуулах;
- Гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар тулгамдсан асуудалд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах;
- Гүйцэтгэгчээс ирүүлсэн санхүүжилт хүссэн гүйцэтгэлийн бичиг баримтыг үнэн зөв хянасан эсэхийг баталгаажуулах;

3.5.6. **Санхүү аж ахуйн хэлтэс** дараах байдалтай оролцоно.

- Санхүүгийн хэлтэс гүйцэтгэгчээс ирүүлсэн санхүүжилт хүссэн гүйцэтгэлийн бичиг баримтад өмнө авсан санхүүжилт таарч байгаа эсэх, арифметик алдаа байгаа эсэх, гэрээний иж бүрдэлд ирүүлсэн банкны баталгааны үнэн зөв эсэх, хөрөнгийн захирамж, санхүүжилтын хуваарийн дагуу байгаа эсэхийг болон гэрээний үнийн дүн түүнд заагдсан захиалагчийн хяналтын зардлын дүнг шалгаж **тухайн өдөрт нь** баталгаажуулна.

3.5.7 Барилгын ажлын явцын хяналтын үе шатанд **Хууль, дотоод хяналтын алба** дараах байдалтай оролцоно.

- Дотоод хяналт шаардлагатай тохиолдолд, батлагдсан удирдамжийн дагуу хөндлөнгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж, газрын удирдлагад тайлагнана.

3.6. БАРИЛГЫН АЖИЛ ДУУСГАХ ҮЕ ШАТ

3.6.1. Барилгын ажил дууссаны дараа ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг Засгийн газрын 2017 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан “барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу гүйцэтгэгчтэй хамтран зохион байгуулна.

3.6.2 Комиссын акт баталгаажсны дараа хяналтын инженер, гүйцэтгэгчтэй хамтран барилга байгууламжийг ашиглагчид **хүлээлгэн өгнө**. Ашиглагч байгууллага тодорхойгүй бол Нийслэлийн Өмчийн харилцааны газарт мэдэгдэл хүргүүлнэ.

3.6.3 Гүйцэтгэгчээр барилгын ажлын гүйцэтгэлийг хөрөнгийн нэр, төрөл, тоо, хэмжээ тус бүрээр *Итохижилтын ажлын хувьд тоглоом, хайс, хашаа, ногоон байгууламж г.м, барилгын ажлын хувьд барилга, инженерийн шугам сүлжээ - дулааны шугам, бойлер, насос, худаг, цэвэр усны шугам, бохир усны шугам; үерийн байгууламж - үерийн далан, борооны ус зайлуулах шугам, худаг, суваг; хашаа, тохижилт, барилгын дотор засвар, гадна засвар гэх мэт/ гаргуулж, барилгын ажлын техникийн баримт бичгүүдийг бүрдүүлнэ.*

3.6.4. Энэ журмын 3.6.3-д заасан баримт бичгийг бүрдүүлсний дараа гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээг энэ журмын хавсралт **маягт №5² “Барилгын ажлын гэрээ дүгнэсэн протокол”**-ын дагуу дүгнэж, санхүүжилтийн эцсийн тооцоог хийхээр гүйцэтгэлийн бичиг баримт бүрдүүлж, энэ журмын дагуу хянуулна.

3.6.5 Комиссын акт баталгаажиж эцсийн санхүүжилтийг олгосноос хойш ажлын **5 хоногийн** дотор хяналтын инженер барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгүүлэхээр хавсралт **Маягт №4² “Барилгын ажлын техникийн бичиг баримтыг НӨХГ-т хүргүүлсэн акт”**-ын дагуу бүрдүүлэн Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлж **ажлыг дуусгах ба НӨХГ-т хүргүүлсэн актыг Санхүү, аж ахуйн хэлтэст** хүлээлгэн өгнө.

3.6.6. Хяналтын инженер гэрээт ажил дуусгавар болсон улиралд багтаан техникийн баримт бичгийн бүрдлийг хавсралт **маягт №6² “Барилгын ажлын баримт бичгийн бүрдэл”**-ийн дагуу бүрдүүлэн архивын нэгж болгон архивт хүлээлгэж өгнө.

3.6.7. Ахлах инженер, хяналтын инженер нь барилгын баталгаат хугацаанд барилга байгууламжийн ашиглалтын байдалд хяналт тавьж, гүйцэтгэгчээс шалтгаалсан эвдрэл гэмтэл гарсан нөхцөлд гүйцэтгэгч байгууллагын зардлаар засварлуулж хэвийн ажиллагааг хангуулж ажиллана.

3.6.8. Барилгын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, Сангийн сайдын 2016 оны Журам шинэчлэн батлах тухай 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”, энэ журмын хавсралт **маягтын** дагуу Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан хүлээн авч гүйцэтгэлийн үе шат бүрээр энэхүү журамд заасан хугацаанд холбогдох албан тушаалтнууд хянаж баталгаажуулна.

3.6.9. Гүйцэтгэл баталгаажигдах явцад засвар оруулах тохиолдолд хавсралт **маягт №8**-ийн дагуу **Хяналтын хуудас** хөтлөж, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан хүлээн авч, буцаан олгоно.

3.6.10. Хяналтын картыг гүйцэтгэл хүлээн авах бүрт 2% үйлдэнэ. Хяналтын картын нэг хувийг Санхүүгийн мэргэжилтэн архивын нэгж болгон хадгална.


ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

4.1 Энэхүү журамд зааснаас бусад харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

4.2 Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтаны үйлдэл эс үйлдэхүй, хохирлын хэмжээнээс шалтгаалж байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн хууль бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулна.

оОо

Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын
даргын 2018 оны 09 сарын 16-ний өдрийн
А/57 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Маягт №11

**ЗУРАГ ТӨСЛИЙН АЖЛЫН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙГ
МАГАДЛАН ШАЛГАХ ХЯНАЛТЫН КАРТ**

Гэрээ байгуулах ажлын нэр:
Гүйцэтгэгч компани:

| | | |
|--|------------------------------------|---------------------------------|
| Зөвлөмж гарсан огноо | | |
| Зөвлөмж хүлээн авсан огноо | | |
| Хөрөнгийн захирамж № | | |
| Гэрээ хэрэгжүүлэх гүйцэтгэгч: | | |
| Тухайн ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл | | |
| Гүйцэтгэгчийн тендерийн материал: | Үнийн санал: | |
| | Хүчинтэй хугацаа: Дуусах огноо: | |
| | Архитектур төлөвлөлтийн даалгавар: | Газрын захирамж, байршлын схем: |
| | | |
| Тендерийн материал шаардлага хангасан эсэх | | |
| 8. Шийдвэрлэсэн нь | | |
| | | |

Анхааруулга:

Олгогдсон газрын захирамж, трасс, байршлын схемийн дагуу одоогийн байдлын фото зураг авч баримтжуулах, зураг төсвийн шатанд гарч болох хүндрэл, шийдвэрлэх шаардлагатай арга хэмжээний талаарх дүгнэлт бичиж хавсаргасан байх

ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА

/

ШАЛГАСАН :

ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

/

**БАРИЛГЫН АЖЛЫН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙГ
МАГАДЛАН ШАЛГАХ ХЯНАЛТЫН КАРТ**

Гэрээ байгуулах ажлын нэр:
Гүйцэтгэгч компани:.....

| | | |
|---|------------------------------|--------------|
| Зөвлөмж гарсан огноо | | |
| Зөвлөмж хүлээн авсан огноо | | |
| Хөрөнгийн захирамж № | | |
| Гэрээ хэрэгжүүлэх гүйцэтгэгч: | | |
| Тухайн ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл | | |
| Ажлын зураг төсөв бүрэн эсэх | Хяналтын төсөв | |
| | Цахилгаан | |
| | Холбоо | |
| | Дулаан | |
| | Цэвэр бохир | |
| | Ажлын зураг | |
| | Инженер геологийн дүгнэлт | |
| | Экспертизийн дүгнэлт | |
| 7. Ажлын тоо хэмжээ | | |
| 8. Гүйцэтгэгчийн тендерийн материал | Үнийн санал: | |
| | Хүчинтэй хугацаа: | |
| | Банкны баталгааны дүн: | Дуусах огноо |
| 9. Материалын үнийн сонголт | | |
| Тендерийн материал шаардлага хангасан эсэх | | |
| 11. Гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлэх эсэх | | |
| 12. Шийдвэрлэсэн нь | | |
| | | |

ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА /...../

ШАЛГАСАН:
ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР /...../

ЗУРАГ ТӨСЛИЙН АЖЛЫН ГЭРЭЭНИЙ ХЯНАЛТЫН КАРТ

Ажлын нэр:.....

Гүйцэтгэгч компани:.....

| № | Гэрээ хүлээн авсан албан тушаалтан | Огноо | | Гарын үсэг | Тайлбар |
|----|---|--------------|-----------------|------------|---------|
| | | Хүлээн авсан | Хүлээлгэн өгсөн | | |
| 1 | Гүйцэтгэгч | | | | |
| 2 | / Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв/ НХОГ-ын ДҮАХ мэргэжилтэн | | | | |
| 3 | Зураг төслийн хяналтын инженер | | | | |
| 4 | Зураг төслийн Ахлах инженер | | | | |
| 5 | ХДХА-ны ХАХ мэргэжилтэн | | | | |
| 6 | ЗТХ-ийн дарга | | | | |
| 7 | НХОГ-ын ерөнхий нягтлан бодогч | | | | |
| 8 | ХОТЗТХ орлогч дарга | | | | |
| 9 | НХОГ-ын дарга | | | | |
| 10 | Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн | | | | |
| 11 | Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга | | | | |

ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР :

/...../

БАРИЛГЫН АЖЛЫН ГЭРЭЭНИЙ ХЯНАЛТЫН КАРТ

Ажлын нэр:.....

Гүйцэтгэгч компани:.....

| № | Гэрээ хүлээн авсан албан тушаалтан | Огноо | | Гарын үсэг | Тайлбар |
|----|--|--------------|-----------------|------------|---------|
| | | Хүлээн авсан | Хүлээлгэн өгсөн | | |
| 1 | Гүйцэтгэгч | | | | |
| 2 | /Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв/ НХОГ-ын ДУАХ мэргэжилтэн | | | | |
| 3 | Хяналтын инженер | | | | |
| 4 | Бүсийн ахлах инженер | | | | |
| 5 | ХДХА-ны ХАХ мэргэжилтэн | | | | |
| 6 | Барилга захиалагчийн Хэлтсийн дарга | | | | |
| 7 | НХОГ-ын ерөнхий нягтлан бодогч | | | | |
| 8 | Ерөнхий инженер | | | | |
| 9 | НХОГ-ын дарга | | | | |
| 10 | Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн | | | | |
| 11 | Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга | | | | |

ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР: /...../

ЗОХИОГЧИЙН ХЯНАЛТЫН ГЭРЭЭНИЙ ХЯНАЛТЫН КАРТ

Ажлын нэр:.....

Гүйцэтгэгч компани:.....

| № | Гэрээ хүлээн авсан албан тушаалтан | Огноо | | Гарын үсэг | Тайлбар |
|---|--|--------------|-----------------|------------|---------|
| | | Хүлээн авсан | Хүлээлгэн өгсөн | | |
| 1 | Гүйцэтгэгч | | | | |
| 2 | /Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв/ НХОГ-ын ДҮАХ мэргэжилтэн | | | | |
| 3 | Хяналтын инженер | | | | |
| 4 | Ахлах инженер | | | | |
| 5 | ХДХА-н ХАХ мэргэжилтэн | | | | |
| 6 | Хэлтсийн дарга | | | | |
| 7 | НХОГ-ын Ерөнхий нягтлан бодогч | | | | |
| 8 | Ерөнхий инженер | | | | |
| 9 | НХОГ-ын дарга | | | | |

ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР: /...../

**ЗУРАГ ТӨСЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХЯНАЛТЫН КАРТ**

Ажлын нэр:.....

Гүйцэтгэгч компани:.....

| № | Гүйцэтгэл хүлээн авсан албан тушаалтан | Огноо | | Гарын үсэг | Тайлбар |
|----|---|-----------------|--------------------|------------|---------|
| | | Хүлээн авсан | Хүлээлгэн өгсөн | | |
| 1 | Гүйцэтгэгч | | | | |
| 2 | /Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв/ НХОГ-ын ДҮАХ мэргэжилтэн | | | | |
| 3 | Зураг төслийн Хяналтын инженер | | | | |
| 4 | Ахлах инженер | | | | |
| 5 | ЗТХ-ийн дарга | | | | |
| 6 | НХОГ-ын ерөнхий нягтлан бодогч | | | | |
| 7 | ХОТЗТХ Орлогч дарга | | | | |
| 8 | НХОГ-ын дарга | | | | |
| 9 | Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн | | | | |
| 10 | Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга | | | | |

ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР:

/...../

**БАРИЛГЫН АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТЫН КАРТ**

Ажлын нэр:.....

Гүйцэтгэгч компани:.....

| № | Гүйцэтгэл хүлээн авсан албан тушаалтан | Огноо | | Гарын үсэг | Тайлбар |
|----|--|--------------|-----------------|------------|---------|
| | | Хүлээн авсан | Хүлээлгэн өгсөн | | |
| 1 | Гүйцэтгэгч | | | | |
| 2 | /Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв/ НХОГ-ын ДҮАХ мэргэжилтэн | | | | |
| 3 | Хяналтын инженер | | | | |
| 4 | Ахлах инженер | | | | |
| 5 | Хэлтсийн дарга | | | | |
| 6 | НХОГ-ын ерөнхий нягтлан бодогч | | | | |
| 7 | Ерөнхий инженер | | | | |
| 8 | НХОГ-ын дарга | | | | |
| 9 | Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн | | | | |
| 10 | Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга | | | | |

ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР: /...../

ЗУРАГ ТӨСӨЛ, ТӨСӨВТ ЗАСВАР ХИЙХ САНАЛ, ЗӨВЛӨМЖИЙН КАРТ

20... оны ...-р сарын ...-ны өдөр

Дугаар ...

Барилга байгууламжийн хүчин чадал:

Байршил:

Зураг төслийн захиалагч:

Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгч:

Зургийн шифр:

Зохиогч:

.....

| Засах шаардлагатай санал зөвлөмжийн утга | Засвар орсон эсэх |
|---|-------------------|
| | |
| | |
| | |
| | |
| | |
| | |

НХОГ-ын хяналтын инженер:

/ _____ /

ЗУРАГ ТӨСӨЛ ХҮЛЭЭЛЦСЭН АКТ

20... оны ...-р сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Барилга байгууламжийн хүчин чадал:

Байршил:

Зураг төслийн захиалагч:

Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгч:

Зургийн шифр:

Зохиогч:

| № | Иж бүрдэл | Зураг төсвийн нэр | Хуудасны марк, тоо | Хувилсан хувийн тоо | Тайлбар |
|---|----------------------------|-------------------|--------------------|---------------------|---------|
| 1 | Ажлын зураг | | | | |
| 2 | Төсөв | | | | |
| 3 | Инженер геологийн дүгнэлт | | | | |
| 4 | Магадлалын ерөнхий дүгнэлт | | | | |

ХҮЛЭЭН АВСАН:

БЗХ-ИЙН ДАРГА

/ /
АХЛАХ ИНЖЕНЕР

/ /
ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

/ /

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:

ЗТХ-ИЙН ДАРГА

.....
АХЛАХ ИНЖЕНЕР

ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР
.....

**БАРИЛГЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН БИЧИГ БАРИМТЫГ
НӨХГ-Т ХҮРГҮҮЛСЭН АКТ**

20... оны ...-р сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Ажлын нэр:.....

Гүйцэтгэгч компани:.....

| № | Баримт бичгийн нэр | Хуудасны тоо | Огноо, дугаар |
|---|--|--------------|---------------|
| 1 | Өмч бүртгүүлэх тухай албан бичиг | | |
| 2 | Хөрөнгийн захирамж, шийдвэр | | |
| 3 | Ажил гүйцэтгэх гэрээ | | |
| 4 | Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссийн акт | | |
| 5 | Гүйцэтгэлийн төсөв буюу хөрөнгийн задаргаа | | |
| 6 | Фото зураг /файлаар/ | | |
| 7 | Ажлын зураг /гадна инженерийн байгууламжийн хувьд/ | | |
| 8 | Далд ажлын акт /гадна инженерийн байгууламжийн хувьд/ | | |

ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР:

/...../

ХҮЛЭЭН АВСАН:

/...../

ЗУРАГ ТӨСВИЙН АЖЛЫН ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ПРОТОКОЛ

Дугаар №

... он ... сар ... өдөр

| | |
|---|--|
| Гэрээний нэр | |
| Гэрээний дугаар | |
| Захиалагч байгууллага | |
| Гүйцэтгэгч байгууллага | |
| Гэрээгээр ажил эхлүүлэх хугацаа | |
| Гэрээгээр ажил дуусгах хугацаа | |
| Гэрээний дүн | |
| Батлагдсан гүйцэтгэлийн дүн: Зураг төсөв: төгрөг Техник хяналт: төгрөг | |
| Санхүүжилтийн дүн: Үүнээс олгогдсон: төгрөг | |
